

## “СЭЛЭНГИЙН” ХЭМЭЭХ ЗОСОН ЗУРГУУДЫГ ШИНЭЭР ТАЙЛБАРЛАХ НЬ

### З.Батсайхан

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны сургууль, Антропологи-Археологийн тэнхим, Batsaikhan@num.edu.mn

**Түлхүүр үг:** зосон зураг, дөрвөлжин хашлага, цэг, хүн, шувуу

Эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэлийг судлах нэгэн чухал хэрэглэгдэхүүн бол хадны зураг юм. Ялангуяа археологийн утга зохиолд “сэлэнгийн” хэмээн нэрлэсэн хадны зосон зурагууд бидний сонирхон буй асуудалд хариу өгөх мэдээлэлийг агуулснаараа анхаарал татаж байна.

Энэхүү зосон зургууд Төв ба Умард монгол, Өвөр Байгалын нутаг хүртэлх өргөн уудам нутагт тархсан сэдэв, дүрслэл, зохиомжийн нэгдэл нь ижил төстэй нэгэн цаг үед хамаарах дурсгал билээ. Зохиомжийн нэгдлийг үзэхэд цэг бүхий дөрвөлжин хашлага, гар гараасаа хөтлөлцөн бүжиглэх хүмүүс, далавчаа дэлгэсэн шувуу, морь, хөндлөн хос зураас, хэрээс тэмдэг зэргээс бүрдэнэ. Эдгээр дүрсүүдийг бүгдийг нь нэгтгэсэн агуулгын хувьд өргөн дэлгэр сонгодог зургийн жишээ болгон Гачууртын амны зургийг нэрлэж болох бөгөөд дор товч тодорхойлж үзье.

Гачууртын хадны зургийн зүүн хэсэгт хоёр жижиг хашлага дүрсэлсний нэгийх нь дотор 12 цэг зурсан, нөгөө хашлагын дотор хэрээс маягийн дүрс зурж 4 хуваажээ. Үүний доор ямар нэг амьтан, хөтлөлцсөн хоёр хүн зуржээ. Зохиомжийн баруун талаар гурван том, нэг багавтар дөрвөлжин хашлага тэдгээрийн дотор болон гадна талд гар гараасаа хөтлөлцөн бүжиглэж буй хүмүүс мөн нэг морь зэргийг дүрслэж хашлага бүрийн дотор олон цэг зуржээ. Уг зохиомжийн дээд хэсэгт хос хөндлөн шугам татаж дээд, доод талд нь хоёр хоёроор нь тус бүр нэг нэг морь хөтлөн явж буй хүмүүсийн дүрс байх ба мөн далавчаа дэлгэсэн хоёр шувуу (бүргэд) нэг хүн байна. Энэхүү зургийн хойт талд нэг морь, таван хүнийг дөрвөлжин хашлагын дотор, гадна талд нь хоёр хүн дүрсэлсэн ажээ. Дээрх зохиомжуудын хамгийн хойт талд хоёр тал хашлага, хүн, морь, шувуу болон нэг үл танигдах амьтан зэргийг дүрслэн үзүүлжээ. Их тэнгэрийн ам, Бичигт булан, Толжгий боом (Хөвсгөл аймаг), Бичигт хад (Булган аймаг) зэрэг газрын зосон зургууд зохиомж, сэдэв дүрслэлийн хувьд ижил боловч зарим нэг жижиг ялгаа бий. Тухайлбал: зэрлэг гахай, чоно, нохой, янгир, нум сумаар харваж буй хүмүүс зэргийг дурдаж болохоос гадна зарим зурагт хүн болон адууг хүйс ялгах тэмдэгтэй дүрсэлсэн байдаг.

А.П.Окладников зэрэг судлаачид дээрх зосон зургуудыг тайлбарлахдаа шувуугаар тэнгэрийн сүр хүчийг, туурайтан амьтнаар доод ертөнцийг бэлгэдэн үзүүлсэн зан үйлийн ёслол (ритуал) гэсэн байхаас гадна Якутын хаврын баяр ысыха хэмээхтэй ойр төстэй гэжээ (1970:168). Мөн Д.Дорж, Э.А. Новгородова, А.В.Тиваненко нар мал сүрэг үржин өсөхийг бэлгэшээн үзүүлсэн зураг гэдэгт санал нэгдэж зарим дүрсийн бэлгэдлийг дээрхтэй ойролцоо байдлаар тайлбарласан байна (1963:9-15,1984:90-97,1990). Эдгээр судлаачид хөтлөлцөн зогсох хүний дүрсүүдийг бүжиглэж буй хүмүүс гэж үзсэн байхаас гадна уг зургуудийн тархалт дөрвөлжин булш дэлгэрсэн нутагтай тохирч байгааг тэмдэглээд хүрлийн хожуу үеийн дурсгал гэжээ (Новгородова 1984: 90,97).

Бидний бодлоор дээрх зосон зургууд зөвхөн мал сүрэг өсөх үржихийн бэлгэдэл төдий бус манай дэлхий ертөнцийн загвар, үхэл, амьдралын тухай болон түүнтэй холбоотой янз бүрийн төсөөлөл, шүтлэг бишрэл, зан заншилыг багтаасан үлэмж өргөн хүрээтэй мэдээллийг агуулсан дурсгал гэж үзэж байна.

Эртний хүмүүсийн оюуны соёлд ертөнцийн үүсэл гарлын тухай ойлголт томоохон байр суурь эзлэнэ. Уул үзэл санааны бүх элементүүд ертөнцийн тухай домгийн бүтэцтэй янз бүрийн байдлаар харилцан холбоотой байдаг оршино. Үүний нэг нь ертөнцийн мод хэмээх ойлголт төсөөлөл болно. Энэхүү мод дээд, доод ертөнцийн бэлгэдэл болохоос гадна түүний иш нь дөрвөлжин хэлбэртэй бөгөөд орон зай босоо бүтэцтэй холбоотой байна. Цөөнгүй тохиолдолд модны эргэн тойрон болон дөрвөлжин хэлбэрт ертөнцийн уулын тал бүрт ижил зайд дөрвөн амьтан дүрслэн орон зайн босоо бүтэцийг илэрхийлсэн байдаг.

Дөрвөлжин дүрс, эртний хятадын уламжлалт үзлээр нөгөө ертөнцийг бэлгэдсэн ертөнцийн уул болохоос гадна алс тэртээ нар шингэх баруун зүгт орших бөгөөд мөн дөрвөлжин уул гэж нэрлэж байжээ (х.193). Ер нь ертөнцийн мод уул гэх зэрэг нэн эртний гэсэн ойлголт төсөөллүүд судлаачдын үзэж байгаагаар дээд палеолитийн үед үүсэж хожим нь тодорхой угсаатны бүлгийн хүрээнд салбарлан хөгжихдөө янз бүрээр хувьсан өөрчлөгдсөн боловч үндсэн гол ойлголтууд нь хадгалагдан хоцорсон байна.

Төв Азийн ард түмний мөнөөх ертөнцийн мод болон уулын тухай эртний үзэл санаа, бөөгийн ёсон болон домог зүйд тодорхой хэмжээгээр уламжлагджээ.

Сурвалжид “Ухуань нарын шүтэн биширдэг Чишань уул Ляодунгаас зүүн хойт зүгт байдаг. Энэ ууланд үхэгсдийн сүнс буцаж ирдэг” гэж үздэг байхад Бурхан Халдун уул монголчуудын өвөг дээдсийн сүнс сүлдийг хадгалсан их тахилга бүхий домогт газар байлаа. Тэрчлэн Мохэ нарын ариун газрын тухай, “тэдний улсын өмнөд этгээдэд хэсэг том уул байх бөгөөд вэй нар түүнийг Тайбо хэмээн нэрлэдэг. Энэхүү уулаас тэд эмээх бөгөөд басхүү хүндэтгэдэг (х.34) зэргээс үзэхэд эдгээр уулууд ертөнцийн уул хэмээх ойлголттой нягт холбоотой байж магадгүй юм.

Алтайн түрэгт хэлт ард түмний ураг төрлийн уул хэмээх ойлголт төсөөлөл нь домог зүйд ертөнцийн төвийн байр суурь эзлэхийн хамт зарим нэг ер бусын шинж чанарыг агуулж байх ба мөнөөх дөрвөлжин дүрс түүний бэлгэдэл болж байсан бололтой (Сагалаев 1992:68).

Буриадын онгон, нанайн ертөнцийн мод зэргийг дөрвөлжин дүрсийн дотор багтаан дүрсэлсэн (зураг) төдийгүй уг зохиомжийн нэгэн гол сэдэв цуварч яваа адуу байгаа нь өгүүлэн буй зосон зурагтай агуулгын холбоотой болохыг харуулж байна. Төв Азийн овог аймгуудын дунд уул хад, чулууг тахин шүтэх явдал түгээмэл дэлгэрсэн бөгөөд эртний хүний ойлголт ёсоор тэдгээр уул, хаданд домгийн амьтас, дээд эмэг өвгүүд (Окладников 1950:337-340) тэдний сүнс элдэв бурхад амьдардгийг дөрвөлжин хашлага буюу ертөнцийн уулан доторхи олон цэгээр дүрслэн үзүүлсэн бололтой ба хүн нас барахад уул, хаданд оршуулах ёс байдгийг дурдаж болно. Нанайчууд ертөнцийн модыг Хонгур сагда гэх бөгөөд тэр модонд хүүхдийн сүнс ангаахай төрхөөр оршдог (Штернберг 1933). Өвгөдийн сүнс болон хүмүүсийг муу зүгийн сүнсээс хүчирхэг жигүүртэн шувуугаар хамгаалуулсан бөгөөд энэ нь хойт Америкийн индианчуудын төсөөллөөр ертөнцийн дөрвөн буланд дөрвөн том шувуу хүмүүсийг хамгаалж байдаг тухай ойлголттой төстэй байна. Мөн Алтайн бөөгийн хэнгэрэгт 8-9 шувуу дүрслэх бөгөөд “Зэс хумст хар шувуу” буюу “Ульгэний шувуу их бүргэд” гэх зэргээр нэрлэдэг байна (Сагалаев 1992:112).

Ийнхүү ертөнцийн босоо бүтэц загвараас гадна хэвтээ загварыг зосон зурагт хос хөндлөн шугамаар илэрхийлжээ. Умард Азийн ард түмний ертөнцийн мод хэмээх ойлголттой төстэй бөөгийн гол гэдэг ойлголт байна (Мелетинский 1976:154). Селькупийн ойлголтоор голын эхэнд дээд тив, дунд нь хүмүүс амьдрах дунд тив, адагт нь доод тив орших бөгөөд дээд, доод тивүүд өмнө болон хойт зүгтэй тохирдог (Прокофьева 1976:113) бол эвенкд бөөгийн гол, үхлийн гол хоёр нэг ойлголт болдог байна (Окладников 1950).

Зосон зургийн хөндлөн хос зураас буюу бөөгийн гол, морь болон хүний дүрстэй нийлж нэгэн зохиомж болж байгаагаас үзвэл нөгөө ертөнцийн тухай

өөрөөр хэлбэл, эртний оршуулгын зан үйлийг харуулж байна. Тухайлбал, морь оршуулгын зан үйлд чухал үүрэг гүйцэтгэх төдийгүй талийгаачийн сүнсийг нөгөө ертөнцөд хүргэх унаа болдог (Галданова 1987 ) нь археологийн судалгаанд тодорхой илэрдэг.

Сурвалжид бичсэнээр ухуань нар хүн нас барахад нэгэн таргалуулсан нохойг эрээн дээсээр хөтлөж явахаас гадна унаж явсан морийг хөтлөж явдаг (х.64). Буриадад цагаан зүсмийн морь тэнгэр, нарын бэлгэдэл болдог зэрэг нэн эртний ойлголтуудыг дурдаж болно. Энэ баримтаас харахад дээрх зосон зургийг зохиомж бүхэлдээ эртний оршуулгын зан үйлийг санагдуулах төдийгүй цаг хугацаа, орон зайн хувьд бараг тохирч байна.


Хүн нас барсны дараагаар өөр ертөнцөд үргэлжлэн амьдарч мал сүргээ өсгөн үржүүлэх, ууж идэх зэргээр энэ ертөнцийн хүмүүсийн хийдгийг хийнэ. Нөгөө ертөнцөд энэ ертөнцийнхтэй адил “ураг төрлийн” болон нийгмийн харьцаа байх ба зарим нэг баримтаас үзвэл энэхүү хоёр ертөнцийн хүмүүс хоорондоо байнга харьцаатай байдаг аж. Гагцхүү, амьд хүмүүс болон үхэгсэдийн хоорондох “уулзалт” хурим болон оршуулгын үед болдог (Галданова 1984) ба МНТ-нд өгүүлэх Ихсийн газар бол мөн л өвөг дээдсийн “уулзалт” тэдэнд зориулан тахилга тайлга өргөх зэрэг эртний уламжлалт зан үйлийг гүйцэтгэх газар байжээ. Энэхүү “уулзалтын” тухай барга бөөгийн дуудлагад ийнхүү өгүүлжээ:

Хадан гэрээс минь уриулаад  
Ханатай гэртээ залсан  
Уулан гэрээс минь уриулаад  
Уньтай гэртээ залсанд чинь  
Үр хүүхэд та нарыгаа  
Үзэж харж ирлээ  
Эцэг болсон шүтээн би  
Өнчин өрөвтөл үр хүүхэд та нарыгаа  
Энэ жилдээ барцадгүй  
Ирэх жилдээ аюулгүй  
Эргэж ирж явна (Далай 1959:33)

Оршуулах ёслол эрт үед баяр ёслолын байдалтай болж өнгөрдөг байсан бололтой. Тухайлбал, ухуань нар хүн нас барахад уйлан гашуудах боловч оршуулгын үед дуулж, бүжиглэж үддэг байсан бол Түрэгүүд оршуулгын өдөр эрэгтэй, эмэгтэй хүмүүс гоё сайхан хувцаслан цугладаг байжээ. Өөр нэгэн домогт өгүүлснээр “Нэгэн баян хүний цэл залуу сайхан охин нь нас барахад эцэг, эх нь ихэд гашуудан харамсаж байсан. Тэр үед талийгаачийг ачиж явсан тэрэг, чаргийг эвдэх заншилтай байснаас гадна оршуулгын газар морь алдаг байжээ. Дараа нь их түүдэг гал ноцоож мах чанаж, уул галыг тойрон харайж ёохор, ёохор хэмээн хашгирдаг” (Галданова 1984:59).

“Монголын нууц товчоон”-нд саглагар модыг тойрон дэвсэн бүжиглэх бүжиг бол дээрх оршуулгын ёслолоор болдог бүжиг түүний хожмын уламжлал мөн бололтой бөгөөд жил бүр Бурхан Халдун ууланд их тахилга явуулж байсныг бас дурдаж болно.


Үхэгсдийг үдэх ёслол нь амьд хүмүүс болон нөгөө ертөнцөд очсон ураг төрлийнхөнтэй “уулзаж” буйн бэлгэдэл, бүх нийтийн наадам болж наадмын үеэр тойрч зогсож ёохор бүжиглэхээс гадна тэдний ар талаар нь үл харагдагч хувхай, бохолдой хэмээх сүнсүүд бүжиглэдэг гэдэгт итгэдэг. Тэр үеэс үлдсэн “наадмын хад” гэдэг нэр бол оршуулах, ёслол зугаа цэнгээний хэлбэртэй болж байснаас гадна хань ижлээ сонгох ёслол нэгэн зэрэг болж байсан тухай хятадын “Умард төрийн түүх”-ийн Түргүүдийн шасдирт оршуулгын үеэс эрэгтэй, эмэгтэй залуучууд бүгд гоёлоон засаж оршуулгын газар цугларан, хэрвээ эрэгтэй нь аль нэг эмэгтэйд үзэж дурласан байвал буцсаны хойно нь тэр дор нь зууч явуулж гуйдаг. Тэгэхэд эмэгтэйн талын эцэг эхийн олонхи нь зөвшөөрдөг (Лин Ган 1998:272 ) гэх энэхүү




5



1, 2, 3



4



6



7

Зосон зураг

1,2,3. Буриад, Монгол бөөгийн онго 4. Их Тэнгэрийн амны зосон зураг 5. Нанайн ертөнцийн мод 6. Гацууртын зосон зураг 7. Алтайн бөөгийн хэнгэрэг

мэдээ баримтаас үзвэл хурим найр нь оршуулгын зан үйлээс эх үндэстэй болохыг харуулж байгаа юм. Ийнхүү оршуулгын үеэр наадам зугаа хийх заншил нэгэн цагт мартагдсан боловч түүний улбаа уламжлал буриадын хуримын зан үйлд үлдэж хоцорчээ.

Өгүүлэн буй зосон зурагт өвөг дээдсийн сүнс орших ертөнцийн уулыг дүрсэлснээс гадна оршуулгын буюу үхдэлийг үдэх ёслол наадам болж байгаа бөгөөд үүний нөгөө тал нь үржих өсөхийн бэлгэдлийг хөтөлцөн бүжиглэх эр, эм хүнээр төлөөлүүлжээ. Мөн оршуулгын ёслолын үеэр бэлгийн харьцааг чөлөөтэй хийж байсныг дүрслэн үзүүлсэн бололтой ба зарим монгол ястны дунд хуримын үеэр бэлгийн харьцааг чөлөөтэй тавьдаг байсан нь эртний оршуулах ёслолоос үлдэж хоцорсон зан заншлын улбаа ажээ (Вяткина 1946:137-144).

Эцэст нь эдгээр зургийг улаан зосоор зурсан нь анхаарал татаж байна. Яагаад гэвэл хүрлийн үед хад чулууг хонхойлон сийлж зурах аргыг эртний хүмүүс хэдийнээ эзэмшсэн байна. Гэтэл зөвхөн дээрх төрлийн зургуудыг улаан зосоор зурсан байдаг. Энэ нь цусыг амьдралын эхлэл гэж үзэх ойлголттой нягт холбоотой нэн эртний шүтлэг бишрэлийн үзэл санаагаар тэдгээр дүрс зургуудыг амьдчилан үзжээ. "Сэлэнгийн" зосон зургуудын өөр нэгэн онцлог бол бүх зурагт дөрвөлжин хашлага, хөндлөн хос зураас, олон цэг, хүн, адуу, шувуу зэрэг дүрсүүд газар бүрт давтагддаг оршино. Гэтэл өмнө өгүүлснээр бөөгийн хэнгэрэг нь дүр дүрслэл, сэдэв, утга агуулгын хувьд зосон зурагтай ижил төстэй байдаг ба шинээр хийх тохиолдолд хуучин зургийг яг байснаар нь дахин хуулж зурах тогтсон ёс нь нэн эртний уламжлалтайн баталгаа ажээ.

"Сэлэнгийн" хэмээх зосон зургууд нэн эртнээс монгол болон Өвөр Байгалаар нутаглаж агсан овог аймгуудын оюуны соёл нийт хүн төрөлхтөний нийтлэг соёлын хүрээнд боловч өөрийн гэсэн онцлогтой хөгжих байсан бөгөөд тэрхүү соёлын олон элемент хожмын монгол болон Төв Азийн бусад ард түмний домог, зан заншил, уламжлалт шүтлэг бишрэлд тодорхой хэмжээгээр хадгалагдан үлджээ.

## **Ном зүй**

- Бичурин Н.Я. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена М.Л., 1950, т.1, с.380
- Вяткина К.В. Пережитки материнского рода у бурят-монголов. СЭ-1946 №1, с.137-144
- Галданова Г.Р. Доламайские верования Бурят. Новосибирск 1987.
- Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг. Эртний судлал, угсаатны зүйн бүтээл. АС. Том II, УБ. 1963
- Далай Ч. Монголын бөө мөргөлийн товч түүх УБ., 1959
- Евсюков В.В. Мифология Китайского неолита. /по материалам росписей на керамике культуры яншаю/ ИКВА. Новосибирск. 1988.
- Золотарев А.М. Родовой строй и первобытная мифология. М:1964, с.154
- Кашина Т.И. Семантика орноментации неолитической керамики Китая В Кн.: У истоков творчества /первобытная искусство/ Новосибирск 1978.
- Лин Ган. Түргүүдийн түүх. Хөх хот.1998
- Мелетинский Е.М. Поэтика мифа М, 1976, с.217
- Новгородова Э.А. Мир петроглифов Монголии. М: 1984. с .92,93
- Окладников А.П. Неолит и бронзовый век Прибайкалья /историко-археологическое исследование/ ч. I, II, М-Л: 1950.
- Окладников А.П. Запорожская В.Д. Петроглифы Забайкалья. Л, 1970. ч.2, с.91,92,126,127
- Окладников А.П. Древнемонгольский портрет, надписи и рисунки на скале у подножия горы Богд-Ула. Монгольский археологический сборник. М:

Прокофьева Е.Д. Старые представлениях народов Сибири и Севера /Вторая половина XIX начало XX в/ Л, 1976, с.113

Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. /Введение, перевод и и комментарии/ М.: 1984.

Сагалаев А.М. Алтай в зеркале мифа. Новосибирск 1992

Тиваненко А.В. Древнее наскальное искусство Бурятии. Новосибирск 1990.

Штернберг Л.Я. Гиляки, орочи, гольды. Хабаровск. 1933

### **Summary**

**Z.Batsaikhan**

#### ***New explanation of ochre paintings in Selenge aimag***

***Ochre paintings found in Mongolia and Zabaikalya display different rituals of nomads funeral, traditions, meeting ancestors, choosing wife, and praying for children. As it has been shown by the research, the composition and content of these paintings are very similar to the paintings on drums of Mongolian and Turkish shamans.***